



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.АМГАЛАНЖАРГАЛ ТАНАА

2017.02.15 № 01/07 ДУА 2017/83/СТА - ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аudit хийх явцад 622,081.00 /Зургаан зуун хорин хоёр мянга наян нэгэн/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ.

1. Ээлжийн амралтын олговрыг 435,581.00 төгрөгийн цалингийн зардалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журмын 5.1-д /Энэхүү журмын 3.2-т заасан эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн албан хаагчид цалингийн зөрүүт тусгайлан олгохгүй бөгөөд тухайн ажилтны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн тувшинг үнэлэхдээ харгалзан үзэж, хууль тогтоомжид заасны дагуу урамшуулал олгож болно/ заасныг,

2. Албан хаагчдад томилолтын нөхөн олговрыг олгохдоо явсан буцаж ирсэн хоногийг буруу тооцсоноос нийт 186,500.00 төгрөгийг илүү тооцож олгосон.

Энэ нь Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолын 3.9-т /Албан томилолтоор ажилласан хоногийн тоог томилолтын үнэмлэхэд тэмдэглэсэн календарьн хоногоор тооцож гаргана. Тэгэхдээ явсан буцаж ирсэн хоногийг нэг хоногт тооцно/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад шээрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомжс, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар

баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.3-д /Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон/ гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:


- Дээрх 622,081.00 /Зургаан зуун хорин хоёр мянга наян нэгэн/ төгрөгийг хавсралтад заасан нэр бүхий ажилтнуудаар нөхөн төлгүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд 2017 оны 04 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлэх,

Актын биелэлтийг 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Амгаланжаргал/, нягтлан бодогч /Б.Сайхантуяа/ нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН¹:

Аудитор



Т.Юун-Эрдэнэ/

Дарга:

Нягтлан бодогч:



ЗӨВШӨӨРСӨН:

/Б.Амгаланжаргал/

/Б.Сайхантуяа/

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зэрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.